

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Хөвсгөл Барилга захиалагчийн хяналтын төв” ОНӨААТҮГ-ын 2025 оны жилийн
эцсийн санхүүгийн тайлангын аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2026/014/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:
www.audit.mn
Хөвсгөл аймаг
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас:88883317 Цахим хаяг: Erdenebaatara@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn
Аудитор: Ц.Чагнаадорж
Утас: 99387994 Цахим хаяг: chagnaadorjts@audit.gov.mn
Бэйкир Тилли Далайван аудит ХХК-ийн Орхон аймаг дахь
салбарын захирал: Д.Мягмарсүрэн
Утас: 99030170, Цахим хаяг: dalaivan.et@gmail.com
Бэйкир Тилли Далайван аудит ХХК-ийн Орхон аймаг дахь
салбарын аудитор: Б.Пүрэвсүрэн
Утас:99921600, Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.16 № 41/295
танай _____ -ны № _____ -т

“ХӨВСГӨЛ БАРИЛГА
ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТЫН ТӨВ”
ОНӨААТҮГ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Б.ГАНЗОРИГ ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Хөвсгөл Барилга захиалагчийн хяналтын төв” ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

“Хөвсгөл Барилга захиалагчийн хяналтын төв” ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Сумын хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 22 сумдад нийт 76 ажил, хувийн хэвшлийн 4 байгууллага, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй А1 төсөл /Жанхайн давааны тохижилт, АБЦ, цахилгаан, гэрэлтүүлэг/ зэрэг ажлуудад захиалагчийн хяналт шалгалтыг хийж дүгнэлт гарган ажилласан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаахаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар 40,998.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, 37,961.7 мянган төгрөгийн алдааг залруулж, төсөв зарцуулалттай холбоотой 3,037.0 мянган төгрөгийн зөрчилд зохих шийдвэрийг гаргаж ажилласан.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд “Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв” ОНӨААТҮГ-ын удирдлага 2 удаа солигдсон байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 40,998.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 37,961.7 мянган төгрөгийн алдааг залруулж, материаллаг бус 1 албан шаардлага, 3,037.0 мянган төгрөгийн 2 зөвлөмжийг хүргүүлсэн.

Залруулсан алдаа :

- Орлого үр дүнгийн тайланд орлогыг НӨАТ-тэй дүнгээр тооцож 37,961.7 мянган төгрөгөөр тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх"; 5.1.5-д "хэмжигдэхүйц байх"; 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 65 дугаар зүйл НББ-ын зарчим дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалт зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна..

3.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй

3.2 Албан шаардлага

- Шилэн дансанд 8 мэдээ хугацаа хоцроомэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх; 6 дугаар зүйлийн 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэж заасныг хэрэгжүүлээгүй ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Тайлагналтай холбоотой асуудал :

Илрүүлэлт: “Хөвсгөл Барилга захиалагчийн хяналтын төв” ОНӨААТҮГ нь байгууллагын бүртгэлийн онцлогт тохирсон, нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, заавар, арга аргачлалд нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж баталж, мөрдөж ажиллах

2. Зардлын данстай холбоотой асуудал :

Илрүүлэлт: Цалингийн тооцооллыг шалгахад НД-ын тайланд тайлагнасан цалин, цалингийн хүснэгтээрх цалин 3,037.0 мянган төгрөгийн зөрүүтэй НД-ын тайланд үндсэн цалинг илүү тайлагнасан байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1.5-д "цалин

хөлсийг тооцох аргачлал ил тод, ойлгомжтой байх, “Нийгмийн даатгалын тухай” хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-т “хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цалингын хүснэгтээрх тооцоолон бодсон цалинг үнэн зөв тайлагнаж байх

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ гэж заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2026 оны 04 дугаар сарын 15-ны өдрийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Завсрын аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Залруулга	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.	1	-					1	-		
нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулаагүй, мөрдлөг болгон ажилладаггүй байна.	1	-					1	-		
Шатахууны зарцуулалтыг шалгахад шатахууныг илүү тооцон зарцуулсан байна.	1	135.0					1	135.0		
Цалинг зөрүүтэй тайлагнасан	1	0					1	0		
Цалинг НД-ын тайланд тайлагнасан боловч цалингийн хүснэгтэд тайлагнагдаагүй Зөрүүтэй тайлагнасан нь 8 401.9 мянган төгрөг байна.	1	23,870.3					1	23,870.3		
ОҮДтайлангийн орлого харилцахын хуулгаар орсон орлого болон татварын тайлангаарх орлоготой зөрүүтэй тайлагнагдсан байна	1	11,311.4							1	11,311.4
Хагас жилийн бараа материалын тооллого хийгдээгүй, 896.0 мянган төгрөгийн үнэт цаасыг тоолж баталгаажуулаагүй байна.	1	896.0					1	896.0		
Бизнес төлөвлөгөөнд тусгагдсан сургалтын зардлаас 1 518.5 мянган төгрөгийг зардал анхан шатны баримтгүй гүйлгээ хийгдсэн байна.	1	1,518.5					1	1,518.5		
Тайлангийн хугацааны эцэст 27,304.1 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	1	27,304.1							1	27,304.1
Шилэн дансанд эхний хагас жилээр 7 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1	-			1	-				
Нийт дүн	10	65,035.2			1	-	7	26,419.8	2	38,615.5

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

												/мянган төгрөгөөр/	
Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
							Залруулсан		Залруулаагүй				
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Орлого үр дүнгийн тайланд орлогыг НӨТ-тэй дүнгээр тооцож 37 961.7 мянган төгрөгөөр тайлагнасан байна.	1	37,961.7			1	37,961.7	1	37,961.7					
Дүн	1	37,961.7			1	37,961.7	1	37,961.7					

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
“Хөвсгөл Барилга захиалагчийн хяналтын төв” ОНӨААТҮГ нь байгууллагын бүртгэлийн онцлогт тохирсон, нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, заавар, арга аргачлалд нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй байна.	1	-					1	-				
Цалингийн тооцооллыг шалгахад НД-ын тайланд тайлагнасан цалин, цалингийн хүснэгтээрх цалин 3 037.0 мянган төгрөгийн зөрүүтэй НД-ын тайланд үндсэн цалинг илүү тайлагнасан байна	1	3,037.0					1	3,037.0				
Дүн	2	3,037.0					2	3,037.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд 8 мэдээ хугацаа хоцроомэдээлсэн байна	1	-	-	-	1	-	-	-
Дүн	1	-	-	-	1	-	-	-